



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/196

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын Х хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан “Ойжуулалт /300 га, Бугат, Сэлэнгэ, Могод, Хангал/”-ын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу дээрх ажлын 1 дүгээр багцын гүйцэтгэгчээр “Ойн таксац” ХХК-ийг сонгож 34 526 000 /гучин дөрвөн сая таван зуун хорин зургаан мянга/ төгрөгөөр, 3 дугаар багцын гүйцэтгэгчээр “Тэнгэрлэг ой” ХХК-ийг сонгож 33 950 000 /гучин гурван сая есөн зуун тавин мянга/ төгрөгөөр, 4 дүгээр багцын гүйцэтгэгчээр “Хөвөнтөн ой” ХХК-ийг сонгож 32 529 000 /гучин хоёр сая таван зуун хорин есөн мянга/ төгрөгөөр, 5 дугаар багцын гүйцэтгэгчээр “Ойн хүрэм” ХХК-ийг сонгож 66 928 000 /жаран зургаан сая есөн зуун хорин найман мянга/ төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.

2. Дээрх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Ойн таксац” ХХК /Д.Баярзориг/, “Тэнгэрлэг ой” ХХК /О.Оюун/, “Хөвөнтөн ой” ХХК /Ч.Оюун/, “Ойн хүрэм” ХХК /Ж.Наранчимэг/-иудад тус тус үүрэг болгосугай.

4. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд “Хөвөнтөн ой” ХХК-ийн ирүүлсэн саналын дагуу орон нутгийн ажилгүй иргэдээс 10 ажиллах хүч ажиллуулж буй эсэхэд хяналт тавихыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /Н.Батжаргал/-д даалгасугай.

5. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Б.ЭДТГ ХӨКЕТХЗасаг дарга

20190200